



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

333.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 144	1409
334.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 145	1410
335.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 146	1410
336.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 147	1411

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

337.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 227	1411
338.	Журам батлах, тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 229	1423

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 144

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хорват Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жаргалсайханы Энхсайханыг эгүүлэн татаж,



Монгол Улсаас Бүгд Найрамдах Хорват Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Словени Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жаргалсайханы Энхсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Словени Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 146

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Словак Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сүрэнгийн Цоггэрэлийг эгүүлэн татаж, Монгол



Улсаас Бүгд Найрамдах Словак Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дорждамбын Зүмбэрэллхамыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 147

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дашдоржийн Баярхүүг эгүүлэн татаж, Лалын Бүгд Найрамдах Афганистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Отгоны Дамбийнямыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 6 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 227

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулга бүхий 749-776 дахь заалт нэмсүгэй:



749.

Дурсгалын нэр: ДЭЭЛ
 Бүтээлч: Тодорхойгүй
 Холбогдох он цаг: XIII-XIV зуун
 Хадгалагдаж буй газар: Монголын үндэсний музей
 Дурсгалын шинж байдал: Торго, 124x94см. Хээ угалзтай торгоор хийсэн. Зах болон баруун ханцуйн үзүүр, баруун талын хормой сэмэрч урагдсан, зүүн ханцуйнаас тасарч байхгүй болсон. Хормойн хоёр талд нугалаастай, ташуу энгэртэй дээл.
 Хувийн дугаар: Y.2005-11-1

750.

Дурсгалын нэр: ДЭЭЛ
 Бүтээлч: Тодорхойгүй
 Холбогдох он цаг: XIII-XIV зуун
 Хадгалагдаж буй газар: Монголын үндэсний музей
 Дурсгалын шинж байдал: Торго, 130x105см. Хээтэй, хул шаргал торгоор хийсэн. Хормойн гол хэсэг болон баруун талын ханцуй, энгэр, зүүн талын ханцуйны голын хэсгээс тасарч алга болсон.
 Хувийн дугаар: Y.2005-11-2

751.

Дурсгалын нэр: ДЭЭЛ (ЯЗГУУРТНЫ)
 Бүтээлч: Тодорхойгүй
 Холбогдох он цаг: XIII- XIV зуун
 Хадгалагдаж буй газар: Монголын үндэсний музей



Дурсгалын шинж байдал: Торго, 135х95см. Ханцуй болон хормой, захаараа угалз хээтэй бор шаргал өнгийн торгон дээл. Хормойн гол хэсэг, зүүн талын ханцуйн хэсэг, энгэрийн зарим хэсэг сэмэрч байхгүй болсон.

Хувийн дугаар: Ү.2005-11-3

752.

Дурсгалын нэр: БҮСНИЙ ЧИМЭГЛЭЛ

Бүтээлч: Тодорхойгүй

Холбогдох он цаг: XIII- XIV зуун

Хадгалагдаж буй газар: Монголын үндэсний музей

Дурсгалын шинж байдал: Алт, зэс. 20 ширхэг алт шармал чимэглэл, 1 ширхэг жижиг товруутай. Нийт 21 ширхэг. Голдоо 5 цагирагтай шармал чимэг 1ш, 6.5х2.3см, жин 12.84гр. Голдоо 3 цагирагтай шармал чимэг 10ш, 4.6х2.2см, жин 102.80гр. Голдоо 1 цагирагтай шармал чимэг 4ш, 2.4х2.2.см, жин 21.62гр. Дөрвөн дэлбээт цэцгэн хэлбэртэй чимэг 4ш, 3.7х3.7см, жин 45.17гр. Шармал арал 1ш, 3.4х2.5см, жин 10.35гр. Жижиг товруу чимэг 1ш, диаметр 1.4 см, жин 2.04гр.

Хувийн дугаар: Ү.2003х-6-2

753.

Дурсгалын нэр: БУРХАН БАГШ

Бүтээлч: Нэр нь тодорхойгүй

Холбогдох он цаг: ХҮIII зуун

Хадгалагдаж буй газар: Богд хааны ордон музей

Дурсгалын шинж байдал: Зээгт наамал. Торго, сувд, шүр, 168х123см, хүрээ торго 313х180см.

Хувийн дугаар: 24-3-06



754.

Дурсгалын нэр: САЙН ЦАГИЙН МЯНГАН БУРХАН
 Бүтээлч: Нэр нь тодорхойгүй
 Холбогдох он цаг: XX зууны эх
 Хадгалагдаж буй газар: Богд хааны ордон музей
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, эх зураг 92x60см, хүрээ 176x91см.
 Хувийн дугаар: 24-6-564

755.

Дурсгалын нэр: САЙН ЦАГИЙН МЯНГАН БУРХАН
 Бүтээлч: Нэр нь тодорхойгүй
 Холбогдох он цаг: XX зууны эх
 Хадгалагдаж буй газар: Богд хааны ордон музей
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, эх зураг 60x92 см, хүрээ 91x176 см.
 Хувийн дугаар: 24-2-565

756.

Дурсгалын нэр: САЙН ЦАГИЙН МЯНГАН БУРХАН
 Бүтээлч: Нэр нь тодорхойгүй
 Холбогдох он цаг: XX зууны эх
 Хадгалагдаж буй газар: Богд хааны ордон музей
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, эх зураг 60x92 см, хүрээ 91x176 см.
 Хувийн дугаар: 24-2-563



757.

Дурсгалын нэр:	УЛААН ЖАМСРАН БУРХАНЫ ЦАМ БҮЖГИЙН ИЖ БҮРЭН ӨМСГӨЛ
Бүтээлч:	Хүрээний нэрт урлаач Пунцаг-Осор, монгол урчууд
Холбогдох он цаг:	XIX зуун
Хадгалагдаж буй газар:	Чойжин ламын сүм музей
Дурсгалын шинж байдал:	Жамсран бурханы цам бүжгийн иж бүрэн өмсгөл: дээл, хормогч, цээживч, бэгз хормогч, бүс, хос гутал, эрхи, арилд, нум, сум, туг болон долоон хор нийт 18ш.
Хувийн дугаар:	Г-42-312 (Жамсрангийн дээл) Г-42-313 (Жамсрангийн хормогч) Г-42-314 (Жамсрангийн цээживч) Г-42-315 (Жамсрангийн бэгз хэмээх хормогч) Г-42-316 (Жамсрангийн бүс) Г-42-317 (Жамсрангийн гутал) Г-42-318 (Жамсрангийн эрхи) Г-42-319 (Жамсрангийн арилд) Г-42-320 (Жамсрангийн нум) Г-42-321 (Жамсрангийн сум) Г-42-322 (Жамсрангийн туг) Г-42-323 (Жамсрангийн хор) Г-42-324 (Жамсрангийн хор) Г-42-325 (Жамсрангийн хор) Г-42-326 (Жамсрангийн хор) Г-42-327 (Жамсрангийн хор) Г-42-328 (Жамсрангийн хор) Г-42-278 (Жамсрангийн хор)



758.

Дурсгалын нэр: В.И.ЛЕНИНИЙ ХӨРӨГ
 Бүтээлч: Б.Шарав (Марзан Шарав)
 Холбогдох он цаг: 1922 он
 Хадгалагдаж буй газар: Монголын уран зургийн галерей
 Дурсгалын шинж байдал: Монгол зураг. Даавуу, гуашь. 152x98см.
 Хувийн дугаар: 52.05

759.

Дурсгалын нэр: “ТАЛЫН АЙЛ”
 Бүтээлч: Төрийн соёрхолт, Ардын зураач Н.Цүлтэм
 Холбогдох он цаг: 1955 он
 Хадгалагдаж буй газар: Монголын уран зургийн галерей
 Дурсгалын шинж байдал: Уран зураг. Зотон, тос. 77x159см.
 Хувийн дугаар: 55.11

760.

Дурсгалын нэр: “АЖЛЫН ДАРАА”
 Бүтээлч: Төрийн соёрхолт, Ардын зураач Г.Одон
 Холбогдох он цаг: 1958 он
 Хадгалагдаж буй газар: Монголын уран зургийн галерей
 Дурсгалын шинж байдал: Уран зураг. Зотон, тос. 160x200см.
 Хувийн дугаар: 58.55

761.

Дурсгалын нэр: “АЗАРГАНЫ НОЦОЛДООН”
 Бүтээлч: Төрийн соёрхолт, Ардын зураач О.Цэвэгжав
 Холбогдох он цаг: 1958 он



Хадгалагдаж буй газар: Монголын уран зургийн галерей
Дурсгалын шинж байдал: Уран зураг. Зотон, тос. 147х200см.
Хувийн дугаар: 58.56

762.

Дурсгалын нэр: “ӨВГӨН ХУУРЧ”
Бүтээлч: Төрийн соёрхолт, Ардын зураач Ү.Ядамсүрэн
Холбогдох он цаг: 1958 он
Хадгалагдаж буй газар: Монголын уран зургийн галерей
Дурсгалын шинж байдал: Монгол зураг. Цаас, гуашь. 60х80см.
Хувийн дугаар: 58.34

763.

Дурсгалын нэр: ХАРХОРУМЫН МОНГОЛ БИЧЭЭСТ 1-Р
ХӨШӨӨНИЙ ХУГАРХАЙ
Бүтээлч: Тогоонтөмөр хааны зарлигаар Шү Юрэн
хэмээх хятад түшмэл бүтээсэн.
Холбогдох он цаг: 1346 он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Боржин чулуун хөшөөний дөрвөн хэсэг.
1. Боржин чулуу. Өндөр 63см, өргөн 48см,
зузаан 40см
2. Боржин чулуу. Өндөр 48см, өргөн 32см,
зузаан 39см
3. Боржин чулуу. Өндөр 34.5см, өргөн 45см,
зузаан 40см
4. Боржин чулуу. Өндөр 13см, өргөн 21см,
зузаан 15см
13-р зууны улс төрийн үйл хэргийг уйгаржин
монгол бичиг болон хятад ханз үсгээр
бичсэн. Бичээсийн утга нь “1220 онд Чингис
хаан Хархорумыг үүсгэн байгуулах зарлиг
буулгасан. Өгэдэй хаан ордноо барьсан.
Мөнх хаан буддын их сүм байгуулсан.
Тогоонтөмөр хааны үед сэргээн засварласан”
гэсэн байна.



Хувийн дугаар: Ү.2010.1.11
ХХМ2012.3.36
ХХМ2012.3.37
ХХМ2012.3.38

764.

Дурсгалын нэр: ХАРХОРУМЫН АРАБ БИЧИГТЭЙ ХӨШӨӨ
Бүтээлч: Тодорхойгүй
Холбогдох он цаг: 1341 он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Боржин чулуу. өндөр 162см, өргөн 81см, зузаан 24см, Суурь: урт 112см, өргөн 65 см, зузаан 27см, Соёмбо: Өргөн 27, урт 61см нүүрэн талд 38 мөр араб бичээстэй, дээр нь соёмбо сийлсэн. Ар талд түвд, санскрит, уйгуржин монголоор маанийн 6 үсэг бичсэн.

Хувийн дугаар: ХХМ2010.1.32

765.

Дурсгалын нэр: ХАРХОРУМЫН МОНГОЛ БИЧЭЭСТ 2-Р ХӨШӨӨ
Бүтээлч: Тодорхойгүй
Холбогдох он цаг: 1347-1348 он
Хадгалагдаж буй газар: Хархорум музей
Дурсгалын шинж байдал: Боржин чулуу. Хөшөөний өндөр 241см, өргөн 89см, зузаан 27см, Суурь: урт 105см, өргөн 78см, өндөр 45см.

Хувийн дугаар: ХХМ2010.1.31

766.

Дурсгалын нэр: ХОТГОР ИЛД
Бүтээлч: Тодорхойгүй



Холбогдох он цаг: XIII зууны үе
Хадгалагдаж буй газар: Монгол цэргийн музей
Дурсгалын шинж байдал: Төмөр. урт 80,7см, өргөн 3,7см, жин 800 гр Илдний голоор өргөн 1,3см, нарийн нь 0,2мм хоёр ховилтой.
Хувийн дугаар: Y-91-6-1

767.

Дурсгалын нэр: ЧОНОН ХӨШӨӨ
Бүтээлч: 1956 онд Архангай аймгийн Ихтамир сумын Бугат багийн нутаг Хаалгатын ам гэдэг газраас археологич Ц.Доржсүрэн малтлагаар олсон.

Холбогдох он цаг: YI зуун
Хадгалагдаж буй газар: Архангай аймгийн музей
Дурсгалын шинж байдал: Боржин чулуу. Согод бичээстэй, гэрэлт хөшөөний өндөр 194см, мэлхий чулуун суурийн өндөр 46см, нийт өндөр нь 238см. Оройн хэсэгт хүүхэд хөхүүлж буй чонын дүрсийг сийлсэн.

Хувийн дугаар: Y-1957-98

768.

Дурсгалын нэр: ХҮРЭЛ МОРЬ
Бүтээлч: Тодорхойгүй
Холбогдох он цаг: МЭӨ YII-III зууны үе
Хадгалагдаж буй газар: Говь-Алтай аймгийн Орон нутаг судлах музей
Дурсгалын шинж байдал: Хүрэл цутгамал. Өндөр 11см, урт 16см, жин 475 гр.
Хувийн дугаар: 1967.21



769.

Дурсгалын нэр:	ИЛГЭН ДЭЭЛ (ЭМЭГТЭЙ)
Бүтээлч:	2005 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Нартын хадны агуйгаас археологич С.Хүрэлсүх, Р.Мөнхтулга малтан олж судалсан.
Холбогдох он цаг:	XIII-XIV зуун
Хадгалагдаж буй газар:	Дорноговь аймгийн музей-сургалт судалгааны төв
Дурсгалын шинж байдал:	Илгэн, энгэр, захны хэсэг байхгүй, дээлийн хоёр ханцуйн хоорондох зай 222см, мөрний хэсгээс хормой хүртэл 145см.
Хувийн дугаар:	08-02

770.

Дурсгалын нэр:	ДААВУУН ДЭЭЛ (ЭМЭГТЭЙ)
Бүтээлч:	2005 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Нартын хадны агуйгаас археологич С.Хүрэлсүх, Р.Мөнхтулга малтан олж судалсан.
Холбогдох он цаг:	XIII-XIV зуун
Хадгалагдаж буй газар:	Дорноговь аймгийн музей-сургалт судалгааны төв
Дурсгалын шинж байдал:	Даавуу, торго. Зүүн ханцуй нь тохойноос урагш урагдаж алга болсон, баруун ханцуйны үзүүрээс зүүн ханцуйны үлдсэн хэсэг хүртэл 155см, дээлийн захаас хормой хүртэл 156см.
Хувийн дугаар:	08-05



771.

Дурсгалын нэр: ТОРГОН ДЭЭЛ (ЭМЭГТЭЙ)
Бүтээлч: 2005 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Нартын хадны агуйгаас археологич С.Хүрэлсүх, Р.Мөнхтулга малтан олж судалсан.
Холбогдох он цаг: XIII-XIV зуун
Хадгалагдаж буй газар: Дорноговь аймгийн музей-сургалт судалгааны төв
Дурсгалын шинж байдал: Улаан торго. Цээж хэсэг бүтэн, хормой болон баруун ханцуйн үзүүрийн хэсэг байхгүй, зүүн ханцуйны үзүүрээс баруун ханцуйн сэмэрхий хүртэл 158см, захаас хормой хүртэл 132см.
Хувийн дугаар: 08-06

772.

Дурсгалын нэр: ДАРЬГАНГА ЭХНЭРИЙН ТОЛГОЙН ГОЁЛ ХАВЧААР
Бүтээлч: Ш.Дондов
Холбогдох он цаг: 1906-1907 он
Хадгалагдаж буй газар: Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей
Дурсгалын шинж байдал: Толгойн гоёл: мөнгө, шүр, даавуу, өндөр 6см, жин 820гр. Хавчаар: мөнгө, шүр, ундром, даавуу, хялгас, өргөн 7,5см, урт 151см, жин 1510гр.
Хувийн дугаар: СҮМ1959.3.1 (Толгойн гоёл)
СҮМ1959.3.2 (Толгойн хавчаар)

773.

Дурсгалын нэр: ҮЗЭМЧИН ЭХНЭРИЙН ТОЛГОЙН ГОЁЛ
Бүтээлч: тодорхойгүй



Холбогдох он цаг: 1950-иад он

Хадгалагдаж буй газар: Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей

Дурсгалын шинж байдал: Толгойн гоёл: мөнгө, шүр, оюу, даавуу.
Өндөр 11.5см, урт 47.5см, жин 1800 гр.

Хувийн дугаар: СҮМ1959.10.2

774.

Дурсгалын нэр: ӨНДӨР ГЭГЭЭНИЙ ЖИРАВ

Бүтээлч: Занабазарын шавь нар

Холбогдох он цаг: XX зууны эх

Хадгалагдаж буй газар: Төв аймгийн музей

Дурсгалын шинж байдал: Зэс хөөмөл, алт шармал, өндөр нь 24.9см,
урт нь 21.2см, зузаан нь 2см, жин нь 3250 гр.

Хувийн дугаар: 83-1181

775.

Дурсгалын нэр: САНДУЙН ЖҮД (НУУЦЫН ХУРААНГУЙ)

Бүтээлч: Нэр нь үл мэдэгдэх бүтээлч

Холбогдох он цаг: XIX зуун

Хадгалагдаж буй газар: Эрдэнэзуу музей

Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороон будаг. Эх зураг:
110.5x206см, хүрээ: 122.2x 215 см.

Хувийн дугаар: 65-1493, 4/108

776.

Дурсгалын нэр: СЭЦЭН ХАНЫ ТАМГА, ТАМГАНЫ ХАЙРЦАГ

Бүтээлч: Нэр тодорхойгүй урлаач



Холбогдох он цаг: 1728 он

Хадгалагдаж буй газар: Хэнтий аймгийн музей

Дурсгалын шинж байдал: Тамга: ган төмөр цутгамал, суурийн хэмжээ 10.9x10.9см, жин 3.9кг. Тамганы хайрцаг: суман мод, мөнгөн тоногтой, улаан хүрэн хамбан дотортой, өндөр 18.2см, өргөн 16.9см, жин 2120 гр. Дардас нь “Халхын Сэцэн ханы тамга” гэсэн монгол, манж бичигтэй.

Хувийн дугаар: 63-8 (тамга)
63-3 (тамганы хайрцаг)

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 6 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар
хот

Журам батлах, тогтоолд нэмэлт оруулах тухай

Боловсролын тухай хуулийн 28.4, Төрийн албаны тухай хуулийн 28.9 -ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сургуулийн нийгмийн ажилтны мэргэшлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журам"-ыг хавсралт ёсоор баталж, 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. "Сургуулийн нийгмийн ажилтны мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээ"-г "Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 219 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт болгон баталсугай.



3. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл хөлс олгоход шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

Засгийн газрын 2013 оны 229 дүгээр
тогтоолын хавсралт

**СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ МЭРГЭШЛИЙН
ЗЭРЭГ, НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны зорилго нь нийгмийн ажилтны мэргэшил, ур чадварын өсөлтийг тодорхойлж, тэдний ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршино.

1.3. Сургуулийн нийгмийн ажилтанд “Ахлах”, “Тэргүүлэх”, “Зөвлөх” гэсэн мэргэшлийн зэрэг олгоно. Мэргэшлийн зэргийг давхардуулан олгохгүй.

Хоёр. Мэргэшлийн зэрэг олгох
шалгуур үзүүлэлт

2.1. Нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг харгалзана:

2.1.1. Нийгмийн ажилтнаар мэргэшсэн болон сургуулийн нийгмийн ажилтнаар ажилласан туршлагатай байх;

2.1.2. Боловсрол судлал, сэтгэл судлал болон хүүхдийн хөгжил, эрх хамгааллын чиглэлээр мэргэшсэн байх;

2.1.3. Ёс зүйн хэм хэмжээг сахин холбогдох хууль, журмыг мөрдөн ажилладаг байх;



2.1.4. Мэдээлэл боловсруулах, судалгаа хийх, гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэг чадвартай байх.

2.2. Нийгмийн ажилтанд мэргэшлийн “Ахлах” зэрэг олгоход дараах тусгай шалгуур үзүүлэлтийг харгалзана:

2.2.1. Сургуулийн нийгмийн ажилтнаар 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;

2.2.2. Нийт суралцагчдынхаа 50-иас доошгүй хувьд хөгжил, төлөвшлийн судалгаа, оношилгоо хийж, судалгааны үр дүнд суурилан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, багш, эцэг эхэд үзүүлсэн зөвлөн туслах үйлчилгээний тоо, чанар;

2.2.3. Сургууль дээр гарсан харилцааны болон хүүхдийн эрхтэй холбоотой бэрхшээл, сурагч, багш, эцэг эхэд тулгарч буй асуудлыг судлан, шийдвэрлэсэн үр дүн, үйлчилгээг холбон зуучилсан байдал;

2.2.4. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, оролцоог хангахад багш, эцэг эх, олон нийттэй бүтээлчээр хамтран ажилласан ажлын үр дүн, тоо, чанар;

2.2.5. Сургуулийн өөрийн үнэлгээний арга зүйг хөгжүүлэн, үнэлгээний дүнг бодит байдлын судалгаатай харьцуулсан дүгнэлт;

2.2.6. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг дэмжин, нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйл ажиллагаанд нийт анги, бүлгийн 50-иас доошгүй хувийг оролцуулж, хамтран зохион байгуулсан байдал.

2.3. Нийгмийн ажилтанд мэргэшлийн “Тэргүүлэх” зэрэг олгоход дараах тусгай шалгуур үзүүлэлтийг харгалзана:

2.3.1. Сургуулийн нийгмийн ажилтнаар 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;

2.3.2. Нийт суралцагчдын 80-аас доошгүй хувьд хөгжил, төлөвшлийн судалгаа, оношилгоо хийж, судалгааны үр дүнд суурилан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, багш, эцэг эхэд үзүүлсэн зөвлөн туслах үйлчилгээний тоо, чанар;

2.3.3. Сургууль дээр гарсан харилцааны болон хүүхдийн эрхтэй холбоотой бэрхшээл, сурагч, багш, эцэг эхэд тулгарч буй асуудлыг судлан, шийдвэрлэх арга замаа оновчтой сонгосон тэргүүн туршлагаа 3-аас доошгүй боловсролын байгууллагад түгээн дэлгэрүүлсэн байх;



2.3.4. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, оролцоог хангахад багш, эцэг эх, олон нийттэй хамтран зохион байгуулсан ажлын үр дүн, чанарт өмнө авсан ахлах зэргийн үр дүнгээс гарсан ахиц;

2.3.5. Сургуулийн өөрийн үнэлгээний арга зүйг түгээн дэлгэрүүлж, үнэлгээний дүнг бодит байдлын судалгаатай харьцуулсан дүгнэлт, шийдэл;

2.3.6. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, багш, эцэг эхийн оролцоотой нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж, үүнд нийт анги, бүлгийн 70-аас доошгүй хувийг хамруулан асуудал шийдвэрлэсэн байдал.

2.4. Нийгмийн ажилтанд мэргэшлийн “Зөвлөх” зэрэг олгоход дараах тусгай шалгуур үзүүлэлтийг харгалзана:

2.4.1. Сургуулийн нийгмийн ажилтнаар 15 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;

2.4.2. Нийт суралцагчдыг 100 хувь хөгжил, төлөвшлийн оношилгоо, судалгаанд хамруулж, судалгааны үр дүнд суурилан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, багш, эцэг эхэд үзүүлсэн зөвлөн туслах үйлчилгээний тоо, чанар;

2.4.3. Сургууль дээр гарсан харилцааны болон хүүхдийн эрхтэй холбоотой бэрхшээл, сурагч, багш, эцэг эхэд тулгарч буй асуудлыг судлан, шийдвэрлэх арга замаа оновчтой сонгосон тэргүүн туршлагаа 5-аас доошгүй боловсролын байгууллагад түгээн дэлгэрүүлж, үр дүнг судлан дүгнэлт хийж, хамтран ажилласан байх;

2.4.4. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, оролцоог хангахад багш, эцэг эх, олон нийттэй хамтран зохион байгуулсан ажлын үр дүн, чанарт өмнө авсан тэргүүлэх зэргийн үр дүнгээс гарсан ахиц;

2.4.5. Багш, ажилтнуудад сургуулийн өөрийн үнэлгээний арга зүйг эзэмшүүлэн, сургуулийн өөрийн үнэлгээний дүнг бодит байдлын судалгаатай харьцуулсан дүгнэлт, шийдэл;

2.4.6. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, багш нарын оролцоотой тухайн оршин суугаа засаг захиргааны нэгжийн тулгамдаж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд анги, бүлэг бүрийг хамруулан асуудал шийдвэрлэсэн жил бүрийн ажлын үр дүн.

Гурав. Мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах

3.1. Нийгмийн ажилтанд олгох мэргэшлийн “Ахлах” зэргийг



тухайн сургалтын байгууллага, “Тэргүүлэх” зэргийг аймаг, нийслэлийн Боловсролын газар, “Зөвлөх” зэргийг үндэсний түвшинд сургалт зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага тус тус хариуцна.

3.2. Нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох дүгнэлтийг тухайн мэргэшлийн зэрэг олгох ажлыг хариуцах эрх бүхий байгууллагын ерөнхий менежерийн шийдвэрээр байгуулагдсан эцэг эх, мэргэжил, арга зүйн байгууллага, мэргэжлийн холбоо, бусад сонирхлын бүлгийн төлөөлөл бүхий ажлын хэсэг гаргана.

3.3. Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий байгууллага бүр мэргэшлийн зэрэг олгосон нийгмийн ажилтны талаарх мэдээллийн санг бүрдүүлнэ.

3.4. Мэргэшлийн зэрэг авахыг хүссэн нийгмийн ажилтан дараах материалыг бүрдүүлж, тухайн сургалтын байгууллагын удирдлагад уламжилна:

3.4.1. мэргэшлийн зэрэг авахыг хүссэн өргөдөл;

3.4.2. тухайн мэргэшлийн зэргийн тусгай шалгуур үзүүлэлтийг хангасан тухай нийгмийн ажилтны өөрийн үнэлгээ, нотлох бичиг баримт;

3.4.3. сургалтын байгууллагын хамт олны хурлын шийдвэр;

3.4.4. 3x4 хэмжээний цээж зураг 2 ширхэг.

Дөрөв. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл хөлс

4.1. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл хөлсийг сарын үндсэн цалингаас Засгийн газрын тогтоолоор тогтоосон хувь хэмжээгээр тооцож олгоно.

4.2. Сургалтын байгууллага, аймаг, нийслэлийн Боловсролын газар, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь гаргасан шийдвэр болон мэдээлэл, хяналт-шинжилгээнд тулгуурлан нийгмийн ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг тооцож, жил бүрийн боловсролын болон байгууллагын төсөвт тусгана.

Тав. Мэргэшлийн зэргийн хүчинтэй байх хугацаа, түдгэлзүүлэх, нөхөн олгох

5.1. Нийгмийн ажилтны мэргэшлийн зэрэг нь түүнд мэргэшлийн зэрэг олгосноос хойш 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.



5.2. Нийгмийн ажилтанд олгосон мэргэшлийн зэрэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нэгэн адил хүчинтэй байна.

5.3. Журмын 5.1- д заасан хугацаа хэтэрсэн болон мэргэшлийн зэргээ ахиулах, “Зөвлөх” зэргээ хамгаалах хүсэлт гаргаж, тухайн мэргэшлийн зэрэгт тавигдах тусгай шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд нийгмийн ажилтанд мэргэшлийн зэргийг олгохгүй.

5.4. Мэргэшлийн зэрэг ахиулах тусгай шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд өмнө олгогдсон мэргэшлийн зэргийг хэвээр үлдээх эсэхийг мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий байгууллага нь шийдвэрлэнэ.

5.5. Нийгмийн ажилтны эрх үүргийг зөрчиж, мэргэжлийн алдаа гарган холбогдох хууль, журмыг зөрчсөн нь тогтоогдвол мэргэшлийн зэрэг олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухайн мэргэшлийн зэргийг 1 жилийн хугацаагаар түдгэлзүүлнэ.

5.6. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд олгох шийдвэр гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу нөхөн олгож болно.

5.7. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэж ашигласан нь тогтоогдвол холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ МЭРГЭШЛИЙН
ЗЭРГИЙН НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ**

№	Мэргэшлийн зэрэг	Үндсэн цалингаас тооцох нэмэгдэл хөлсний хувь
1	“Ахлах”	15
2	“Тэргүүлэх ”	20
3	“Зөвлөх”	25

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 1.25
Индекс: 14003